

**ЦАГДААГИЙН АЛБА, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙН
ХҮРЭЭНД ТУЛГАМДАЖ БҮЙ ЗАРИМ АСУУДАЛ**

Зэвэгийн Цэрэнбат

ОХУ-ын ДХЯ-ны Москвагийн их сургуулийн
адъюкт, цагдаагийн дэд хурандаа

Энэ сэдвийг авч үзэхийн тулд эхлээд цагдаагийн алба, үйл ажиллагааг түүхэн эх сурвалжуудад хэрхэн тэмдэглэн үлдээсэн талаар товчхон өгүүлбэ. Биднийг шөнө хэвтүүл цэрэг хамгаална. Хэвтүүл халаагаа ирэхэд тэмдгээ шилжүүлж өгөөд чөлөөлөгдөнө. Хэвтүүл шөнө ордны орчим байж үүдийг харгалзаж, орохыг завдах хүмүүний мөрийг мулт цохиж, толгойг нь тоншин, цавчиж хаятугай. Хишигтнийг би өөрөө захирч хэрэв ял халдваас би өөрөө шийтгэнэ¹.

Их эзэн Чингис хааны үүсгэнэ байгуулсан хишигтэн / одоо бол төрийн цагдаа / нь эзэн Чингис хааны үед ч, Чингис хаанаас хойш Монгол Улсыг мандуулсан Өгөөдэй, Гүюг, Мөнх, Хубулай, их хаадын үед ч үе улиран залгамжлагдаж, улам бүр хэлбэржин Монголын төрийг хамгаалах дотоодын элдэв зөрчил, тэмцлийг илрүүлэн дарах, төрийн нударга болж оршоор Монголыг Манжид дагаар орсон тэр үед төртэйгээ мөхсөн².

1921 онд Ардын Засгийн газрын 6 дугаар хурлаар “Цагдаагийн тухай” хэлэлцээд ард түмний амь бие, эд хөрөнгөд халдагсадтай тэмцэх, хэв журам, энх амгалан байдлыг сахиулах үүрэг бүхий “Сэргийлэх цэргийн салаа”-г байгуулсан нь Монгол Улсын шинэ үеийн Цагдаагийн байгууллагын үүсэл болжээ. Цагдаагийн байгууллага үүсэн байгуулагдсан цагаасаа хойш улс орны нийгэм, төрийн байгууламжийн хөгжлийн бүхий л үе шатуудад хөгжиж, бэхжиж ирсэн Монгол төрийн ууган байгууллагын нэг юм³.

1966 онд Цагдан сэргийлэх байгууллагын 45 жилийн ойг тохиолдуулан төр, ард түмнийхээ өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж ирснийг төр өндрөөр үнэлж “Байлдааны гавьяаны улаан тугийн одон”-гоор шагнасан юм.

Цагдаагийн байгууллага хөгжлийнхөө явцад гадаад харилцаагаа хөгжүүлэхэд анхаарч ирснээр 1991 онд олон улсын цагдаагийн байгууллага “Интерпол”-д гишүүнээр элсэж, дэлхийн улс орнуудын адил чиг үүрэгтэй мэргэжлийн байгууллагуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа эхлүүлэн ажиллаж байна.

Аливаа нийгэм дахь өөрчлөлт, шинэчлэлтийн зорилго нь өнгөрсөн, одоо, ирээдүйн хөгжлийн тунгаамал байдагт л оршино.

1990 оны нийгмийн ардчилал, шинэчлэл, шилжилтийн үед цагдаагийн байгууллага нь төрийн байгууллагууд дотроос өөрчлөлтийг тухайн үедээ оновчтой хийсэн цөөхөн байгууллагуудын нэг гэж албан ёсоор хүлээн зөвшөөрдөг.

УИХ-ын гишүүн Ц.Нямдорж ”...Яг чин үнэнийг хэлэхэд сүүлийн хорин жилд цагдаа шиг үүргээ сайн биелүүлж ажилласан байгууллага ховор байх⁴...” гэж улс төрчдийн дотроос цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг бодитойгоор үнэлжээ.

¹ . Монголын нууц товчоо 1947 он 224-р зүйл, А.Амар Монголын товч түүх 2-р хэвлэл 1989 он хуудас 126-127.

² . Т. Гомбодаш. Монгол төрийн цагдаагийн түүхийн лавлагаа, тодотгол, судалгааны эх бичгүүдийн хураангуй. /1865-1961/. УБ., 2006 х. 6.

³ . <http://www.zasag.mn/news/view/>

⁴ . “Үндэсний шуудан”. /2011.05.10. №111 (1135) .

Гэхдээ өнөөгийн нөхцөлд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн орчинд өөрчлөлт хийх шаардлага байсан уу гэвэл байсан, тэр нь нийгмийн хөгжлийн явц, эрх зүйн шинэтгэлийн хүрээнд явагдаж буй өөрчлөлт, амьдаралаас урган гарсан гэж үзэж болно.

Цагдаагийн алба хаагчийн ёс зүй, үйл ажиллагааны орчин түүний шинэтгэл, судалгааны тайлан, санал, зөвлөмжинд тэмдэглэхдээ: Цагдаагийн байгууллагын эрх зүйн орчныг зайлшгүй шинэтгэх болжээ... Судалгаагаар цагдаагийн байгууллагад холбогдох хууль эрх зүйн орчин хангалтгүй, давхардал хийдэл ихтэй байна гэж дүгнэжээ⁵.

Харин цагдаагийн алба, үйл ажиллагааны эрх зүйн шинэтгэлийг хийхдээ албаны үнэт зүйлс, ажлын хэвшил болсон дэвшилтэд аргууд, уламжлалыг нь хүндэтгэн үзэж, шинэчлэлийн явц, үр дүнд гарах сөрөг үр дагаврыг тооцож өөрчлөлтийг хийх нь илүү цаг үеэ олсон, оновчтой өөрчлөлт болохоор байв.

Хууль зүйн ухааны доктор Б. Пүрэв “topmedee.mn” сайтад өгсөн ярилцлагадаа: Тухайн үедээ өөрийгөө би маш хүнд үед цагдаагийн даргаар ажиллаж байна даа гэж боддог байв... үгүй юм байна аа. Одоогийнх шиг засгийн газар, яам, улс төрийн намууд цагдаад нэг их оролцдоггүй байсан юм байна... ⁶ гэж өнөөгийн монгол улсын төрийн эрх мэдэл авсан намууд цагдаагийн алба, үйл ажиллагаанд хэрхэн оролцож байгааг тэмдэглэж хэлсэн байна.

Аливаа асуудал, байгууллага улс төржөөд ирэхээрээ утгаа алддаг жишиг Монголын цагдаад ч нүүрлэсээр хэдэн жилийг ардаа орхижээ⁷.

Нийгмийн харилцааг эрх зүйн хэм хэмжээний актуудаар хэсэгчлэн болон бүхэлд нь зохицуулахдаа бусдын загварыг хуулбарлах биш, олон улсын нийтлэг жишгийг харгалзан, өөрийн улс орны уламжлал, ёс заншил, өвөрмөц онцлог, нийгмийн хөгжлийн явц, байдал, ирээдүйд үүсэх эерэг сөрөг үр дагаврыг урьдчилан тооцож, шинэчлэлт хийх нь нийгмийн хүлээлт байсан юм.

Ийм шинэчлэлт хийх эрх нь зөвхөн ард түмний сонголтын үр дүнгээр сонгогдсон эрхэм гишүүд л эдлэх учиртай.

Гэтэл 2012 онд тухайн үеийн УИХ-д суудал бүхий эрх барих намууд сонгуулийн өмнөхөн үндсэн хуулийг зөрчин байж УИХ-ын сонгуулийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах замаар “намын жагсаалтаар УИХ-д суух” боломжийг өөрсдөө тохируулан батлан, мөрдөж, нэр бүхийн этгээдүүд улсын их хуралд хууль бус аргаар орж, тангараг өргөн УИХ-ын гишүүний бүрэн эрхийг эдэлсэн байдаг.

Нэгэнт ард түмнээс сонгогдоогүй намын жагсаалтаар УИХ-д суусан этгээдүүд нь ард түмнийг төлөөлөл болж чадах уу гэдэг асуудал зүй ёсоор тавигдана.

Монгол Улсын үндсэн хуулинд: “УИХ-ын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно”⁸ гэсэн заалтыг бүдүүлгээр зөрчиж, ард түмний сонгох эрхийг намууд ийнхүү булаан авч төлөөний хүмүүсээ их хуралд оруусан байдаг.

Гэтэл өнөөдөр зарим эрхмүүдтэй холбоотой, ноцтой байж болох, гэмт хэргийн шинжтэй, улс орны нийгэм, эдийн засаг, улс төрийн ашиг сонирхолд харш үг, үйлдэлүүдийн талаар гадаад, дотоодын хэвлэл мэдээлэлийн хэрэгсэлээр шуугисаар л байна.

Эрдэмтэн Бө.Батэрдэнэ өөрийн бүтээлдээ: “Төрийн түшээд зохион байгуулалттай гэмт бүлгийн эрх ашгийг төлөөлөх, тэдэнд үйлчлэх нь нөгөө талаас хувь хүний улс төрийн эрх, эрх

⁵ Монгол Улсын Хууль зүйн яам, Хууль сахиулахын их сургууль, Цагдаагийн Ерөнхий газар.

Цагдаагийн алба хаагчийн ёсзүй, эрх зүйн орчин түүний шинэтгэл, судалгааны тайлан санал, зөвлөмж. УБ., 2013.

⁶ Б.Пүрэв: Албан тушаал, ажилласан жилээр олгодог хурандаа цол одоо үзэмжийнх болжээ. Ярилцлага: topmedee.mn. 2014.04.08

⁷ Д.Дамдин. Монголын цагдаа улс төрчдийн өс хонзонгийн бай болох ёсгүй. Монголын үнэн.

⁸ Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992. // Төрийн мэдээлэл сэтгүүл 1992. № 1.

чөлөөнд бүдүүлгээр халдаж байгаа хэрэг мөн”⁹ гэж тэмдэглэснийг санаад өнөөгийн бодит байдал дээр ажиглалт хийхэд зарим нэр бүхий гишүүд төрийг төлөөлөх сэтгэлгүй, ард түмний төлөө биш, намын хэсэгхэн хүний эрх ашиг, гадаадын хэн нэгний эрх ашгийг төлөөлөөд байгааг үгүйсгэхгүй байна.

Манай орны хувьд Цагдаагийн байгууллага нь нийгэм, улс төрийг тогтвортой байлгах, улс үндэсний дотоод аюулгүй байдлыг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд ардчилал, шинэчлэл, өөрчлөлт нэрээр хэт туйлширсан, харалган бодлогын үүднээс бүтэц зохион байгуулалтаар нь хамаагүй оролдох нь цагдаагийн албаны үнэт зүйл, түүхэн уламжлал алдагдаж, ажилтнуудын албаны бахархал үгүй болох, нийгмийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж, гадаад улс болон үндэстэн дамнасан корпорациудын ашиг сонирхолд нийцсэн бодлого хэрэгжих бололцоог нэмэх эрсдэлтэй байна¹⁰. Аливаа нийгмийн хөгжлийн чиг баримжааг эрх зүйн хэм хэмжээний хүчээр эрс өөрчлөх нь гол мөрний усыг сөргүүлж урсгаж болдоггүйтэй адилтган зүйрлэж болно.

Ингээд улс орны өнөөгийн нөхцөл байдал, цагдаагийн алба, үйл ажиллагааны эрх зүйн орчинд хийгдэж байгаа өөрчлөлт шинэчлэлтэй холбоотой дараах асуудлыг хөндөж байна.

1.Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг, үүрэг бүхий зарим байгууллагуудын үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг ямар нэгэн судалгаагүйгээр өөрчилж мөрдөх албаны, цагдаагийн албаны, тахарын албаны, гадаадын харьяатын, хилийн шалганы гэх мэтээр тус тусдаа хуулиар зохицуулагдахаар болгон, бие даалгаж, тараасан нь Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”-д “Төрийн үйлчилгээг хүртээмжтэй, ил тод болгох, хүний эрхийг баталгаатай хангах, нийгэм дахь аюулгүй орчныг бий болгох эрх зүйн зохицуулалтыг тус тус боловсронгуй болгоно”¹¹ гэсэн төрийн бодлоготой зөрчилдөж, байгууллагуудын ажлын уялдаа холбоо алдагдах, удирдлага, зохион байгуулалт, хүчин чадал суларч, төр, ард түмнийхээ өмнө хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд сөрөгөөр нөлөөлж болзошгүй байна.

2.Манай улсын геополитикийн ашигтай байрлал, уул уурхайд ашигт малтмалын олборлолт нэмэгдэж, түүнд тавих төрийн хяналт сул, байгалийн тэнцвэртэй байдал алдагдах магадлал ихэссэн, авилга, хээл хахуулын гэмт хэрэгт зарим төрийн өндөр албан тушаалын эрхмүүд холбогдсон, төр, засагт иргэдийн итгэх итгэл буурч, өргөн хэрэглээний барааны үнэ өссөн, ажилгүйдэл, ядуурал нэмэгдсэн, шударга бус аргаар баяжихыг хүсэгчдийн тоо нэмэгдсэн, хүний хүмүүжлийн тогтолцоо бодит утгаараа алдагдсан, гэмт хэргийн гаралт эрс нэмэгдсэн зэрэг олон сөрөг ур дагаварууд улс орны дотоодод гарч байгаа өнөө үед дотоодын цэргийн ангиудыг татан буулгасан нь монгол улсын түүхэнд ямаг нэгэн байдлаар тэмдэглэгдэнэ үлдэж, хэрхэхийг цаг хугацаа харуулна.

3.Цагдаагийн байгууллагын тугны загвар, хэрэглэх, тангараг өргөх журмуудыг Монгол Улсын Ерөнхийлөгч баталдаг байсан. Гэтэл шинэ хуулиар энэ бүхнийг Хууль зүйн сайд ганцаар баталдаг байхаар болчихлоо. Энэ бол маш буруу. Туг бол тухайн байгууллагын сүр сүлд нь юм¹² гэсэнтэй санал нэг байна.

4.Шинэ хуулиар цагдаагийн алба хаагч тангараг өргөхдөө “иргэдийнхээ өмнө өргөнө...”, гээд “...би энэ тангаргаасаа няцваас хуулийн хариуцлага хүлээнэ...” гэж байгаа. Тиймээс “ард түмэндээ” тангараг өргөх нь, хэн ард иргэдийг төлөөлж чадах вэ? эрх хэмжээтэй субъект л батлах ёстой. Гэтэл хуучин цагдаагийн байгууллагын тухай хуулинд тангарагийн тухай

⁹ Б.Батэрдэнэ. Зохион байгуулттай гэмт хэрэгтэй тэмцэх асуудал ба төрийн байгуулалтын аюулгүй байдал. Нийтлэл. УБ.,2011 // “Цагдаа судлал” онол арга зүйн сэтгүүл.2011/№1.

¹⁰ Д.Дамдин. Монголын цагдаа улс төрчдийн өс хонзонгийн бай болох ёсгүй. Монголын үнэн.www.cak.mn.

¹¹ Цагдаагийн албаны тухай хуулийн үзэл баримтлал. “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл.2013 №4 (46). УБ.,2013. 4 дэх тал.

¹² Б.Пүрэв: Албан тушаал, ажилласан жилээр олгодог хурандаа цол одоо үзэмжийнх болжээ.Ярилцлага: topmedee.mn. 2014.04.8

заахдаа: “...чин шударгаар зүтгэж, шаардлага гарвал амь насаа үл хайрлахаа батлан тангараглая” гэж байсан юм. Одоо яагаад бид эх орон, ард түмнийхээ төлөө амь насаа хайрлах (хоохойлох) ёстой гэж? Бидний өвөг дээдэс өнөөгийн энэ бүрэн эрхт байдал, эрх чөлөө, тусгаар тогтносон улсынхаа төлөө халуун амь, бүлээн цусаа харамгүй зориулж, өргөсөн тангарагтаа үнэчээр зүтгэж, тэмцэж ирснийг бидний үе үеийн түүх гэрчилнэ.

5.Цагдаагийн цолыг алба хаагчид олгох талаар цагдаагийн албаны тухай хуулийн 34.1-д заасан албан тушаалын цолыг түүнийг томилох эрх бүхий албан тушаалтан олгоно¹³ гэж заасан. Өөрөөр хэлбэл алба хаагчийг албан тушаалд томилсон эрх бүхий албан тушаалтан нь томилсон хүндээ албан тушаалын цолыг нь олгохоор болсон.

6.Эрх бүхий албан тушаалтаны эрх мэдэл нь давхар нэмэгдэж, албан тушаалд ч томилно, цолыг нь ч олгоно гэсэн үг. Өнөөгийн нөхцөл байдлаас ажиглахад боловсон хүчний бодлогогүйгээр хэн танил талтай, мөнгөтэй, дарга нарт хэн ойр байгаагаас хамаараад мэргэжлийн мэдлэг, дадлага, туршлагагүй, албаны төлөө гэсэн сэтгэлгүй хүнийг намын харъяалалаар ажилд томилж, цол олгож эхэлбэл төрийн албаны нэр хүнд унах, албаны үнэт зүйлс алдагдах, иргэдийн төрийн албанд итгэх итгэл буурах магадлалтай байна.

Цол нь цэргийн байна уу, цагдаагийн байна уу, албан тушаалын байна уу ялгаа байхгүй, хамгийн гол нь тухайн алба хаагчийг үндсэн үүрэгт ажилаа сайн, сэтгэлээсээ шударга хийх, сайн ажиллуулах, ажлын хөшүүрэг л болж байвал болно. Өөрөөр хэлбэл ажилаа сайн хийж байгаад дараагийнхаа цолыг авна гэсэн ажлын төлөөх тэмүүлэл, би энэ цолыг үнэхээр л ажлын төлөө зүтгэж байж авсан юм шүү гэсэн бахархал л байх учиртай. 1997 онд албан тушаалын цолыг зэвсэгт хүчний хэмжээнд туршиж үзээд жил ч бололгүй, оновчгүй болох нь нотлогдоод хуучнаараа алба хаасан хугацаагаар олгох нь зүйтэй гэсэн дүгнэлтэнд хүрсэн байдаг.

Яагаад гэвэл, албан тушаалын төлөө улайран зүтгэж, ямар ч үнээр хамаагүй түүнд хүрэхээр шунан дурлаж, төрийн албаны нэр хүнд, цэргийн албаны утга учир алдагдахад хүрч болзошгүй болж ирсэн юм.

Цагдаагийн байгууллагын албад, шат шатны удирдах бүрэлдэхүүний томилгоонд аль нэг намын ашиг сонирхол, санал болгосон, мэргэжлийн мэдлэг, ажлын дадлага, туршлагагүй, удирдах арга барилд суралцаагүй хүмүүс цагдааг удирдах болсоноор **монголын цагдаагийн байгууллагын боловсон хүчний бодлого тогтолцоо алдагдсан юм**. Үүнээс үүдэж хууль бус тушаал өгөх, биелүүлэхийг шахах, биелүүлээгүй тохиолдолд ямар нэгэн шалтаг шалтгаанаар ажлаас нь халах, алба хаагчийн хуульд нийцүүлэн гаргасан шийдвэрт хөндлөнгөөс оролцож, бусдад ашигтай байдлаар шийдүүлэх зэрэг шударга бус хандлага цагдаагийн зарим нэг удирдлага нэгж дээр бий болсныг үгүйсгэхгүй.

... Хүн удирдах, зохион байгуулах чадвар маш муу, хуучинсаг арга барилаас салах, алба хаагчдынхаа эрх ашгийг хамгаалах талаар дарга нар юу ч хийдэггүй, **дарга нарын дэмжлэг хэрэгтэй байна**, удирдлагын сэтгэлгээг өөрчлөх, удирдах албан тушаалтнуудын мэдлэг, чадвар, ажлын арга туршлагыг нь харгалзаж, шударгаар томилох гэх мэтээр цагдаагийн алба хаагчид шүүмжлэлтэй хандаж, санал асуулгын хуудсанд тэмдэглэсэн байна¹⁴.

Боловсон хүчний бодлого гэдэг нь: Тухайн мэргэжилийн яамны боловсон хүчний бодлогын алсын хараа, түүний нөөцийг оновчтой, идэвхтэй ашиглах байгууллагын удирдлагын үйл ажиллагааны шийдвэр, хэм хэмжээ, зарчим, бодлогын цогцыг хэлнэ¹⁵ гэж тодорхойлсон.

Манай улсын хэмжээнд **боловсон хүчний бодлого алдагдах** хамгийн гол шалтаг, шалтгаан нь намаар талцах, намын харъяалалаар төрийн байгууллагуудын удирдах ажилтаны томилгоо хийдэг, өөрийн талын хүнийг томилуулахаар эрх мэдэлээр дулдуйдах, намын

¹³ .Цагдаагийн албаны тухай. / Шинэчилсэн найруулга /. “Цагдаа судлал” онол арга зүйн сэтгүүл.2013 / №3.

¹⁴ .З.Цэрэнбат. Цагдаагийн алба хаагчийн захиргааны эрх зүйн хамгаалалтын өнөөгийн байдал, боловсронгуй болгох зарим асуудал. “Цагдаа судлал” онол арга зүйн сэтгүүл. 2014/ №1

¹⁵ . Организация кадровой работы в органах внутренних дел: Курс лекций- М., ДГСК МВД России, 2012. С.5.

харъяалалаар мэргэжилтэй боловсон хүчнийг ажилаас нь халах гэх мэт зохисгүй, шударга бус байдлаас болж, өнөөдөр энэ нь нийгмийн өмнө тулгамдсан асуудал болж, олон сөрөг үр дагаваруудыг бий болголоо, үүнийг хэн ч анзаарахгүй, асуудлыг хэн ч хөндөх сөхөөгүй л байна. ...Өөрийн хүсэлтээр гэх боловсон шалтгаанаар ажлаа өгсөн төрийн албан хаагчид хуулийн дагуу зургаан сарын цалинтай тэнцэх нэг удаагийн тэтгэлэг авсан байх юм. Зөвхөн нэг хүний цалингийн дунджийг 500 мянган төгрөг гэж үзвэл 20 мянган хүн улсын төсвөөс нийт гурван тэрбум төгрөг гаргуулсан байж таарна. Үүнээс харвал засаглалд нүүрлэсэн боловсон хүчний завхрал төрийн байгууллагын чадварыг сулруулахын зэрэгцээ төсвийн санг ч бас нимгэлээд авчээ¹⁶.

Боловсон хүчний бодлого алдагдаж, томилогсон албан тушаалтаны хууль бус ажиллагааны улмаас арга буюу шинэ хуулийн 4.2.5. д “алба хаагч удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг, даалгаврыг хуульд заасны дагуу биелүүлэх, хууль бус үүрэг даалгаврыг биелүүлэхээс татгалзах”. 4.3.д “Цагдаагийн байгууллага, алба хаагчаар хуульд зааснаас өөр ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно”.гэх мэт заалтууд оруулсан нь “зарим этгээдүүд наад үүрэг чинь хууль бус байна гээд үүрэг даалгавар биелүүлэхгүй зарга үүсгээд яваад байж болох” гэх мэт сөрөг нөлөө үзүүлэхгүй гэх баталгаагүй бөгөөд энэ нь дэвшил биш ухарал болж харагдаж байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн гол үзэл санаа нь цагдаагийн алба үйл ажиллагаанд иргэдийн оролцох оролцоог нэмэгдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг чухалчилсан хэдий ч цагдаагийн гүйцэтгэх ажлын талаар учир дутагдалтай хуульчилсан юм.

Гэмт хэрэгтэй тэмцэх ажлын бүхий л үе шатанд, тухайлбал гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, шалгаж шийдвэрлэх, гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг арилгахад гүйцэтгэх ажлыг оновчтой ашиглаж болохоор зохицуулалт хийх нь зүйд нийцэхээр байв.Цагдаагийн албыг иргэншүүлэх нь цагдаагийн алба хаагчийн иргэдтэй харилцах хандлага, харилцааны соёл, аливаа асуудлыг хуулийн хүрээнд, үндсэн хуулийн тулгуур зарчмыг баримтлан шийдвэрлэх тухай асуудал юм. Цагдаагийн албаны өдөр тутмын албаны үйл ажиллагааны зарчим биш. Учир нь цагдаагийн алба нь тайван цагт гэмт хэрэгтэй тэмцэл явуулж байдаг төрийн тусгай алба. Эрдэмтэн агсан Д.Таванжин өөрийн бүтээлдээ Цагдаагийн байгууллагад хаах албаны онцлог нь цагдаагийн бие бүрэлдэхүүнийг тусгай болзол журмын дагуу ажилд авах, цагдаагийн цол олгох, дүрэм журмыг дагаж мөрдөх, тангараг өргөх, нийгмийн хэв журмыг хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг хүлээж түүнээ хэрэгжүүлэх эрх эдлэх, албаны өндөржүүлсэн бэлэн байдалд шуурхай ажиллах явдал оршино¹⁷ гэж оновчтой тодорхойлсон байдаг.

Захиран, захирагдах ёс, тушаал, шийдвэр, үүрэг даалгавар өгөх, биелүүлэх журам мэдэхгүй, удирдлагын менежментын сэтгэл зүйн ядмаг байдал, мэдлэг, чадвар, дадлагагүйн уршигаар цагдаагийн албаны удирдлагын шатны өдөр тутмын үйл ажиллагаанд доголдол гарах магадлалтай.

Удирдлагын дээд шатнаасаа ийм байдлаар эхэлж, доод шатанд үргэлжлэхгүй гэх баталгаа алга, бодит байдал дээр ажил, алба урагшлахгүй гацаанд орж, цагдаагийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа зогсонг байдалд хүрвэл ард иргэд л хохирно.

Ёс цаазат, ичгүүр сонжурт бүгдийг алдсаны харгайгаар орон нутгийн хүмүүс эрхтэний хэлснийг сонсохгүй. Эрхтэнгүүд нь яам тамгынхаа газрын үгийг сонсохоо болино. Энэ мэт орны журам бүр хувьсан солигдож одооноос хамаг юмны журам шүтэн барилдлага самууран одно ...¹⁸.

Удирдлагын энэ багийн өмнө тулгарсан хамгийн гол зорилт бол алба хаагч нийт хамт олны урам зоригийг дээшлүүлэх, одоо л нэг юм зүй зохистой болох нь дээ гэсэн итгэл найдварыг

¹⁶ .Д. Отгонжаргал.Мэргэшсэн 20 мянган түшмэл төрийн албанаас “хулжжээ”. Нийтлэл.Өнөөдөр сонин.2014.05.01.// www.mongolnews.mn.

¹⁷Д.Таванжин. Монгол Улсын “Цагдаагийн эрх зүй”, УБ.,2006.263 дахь тал.

¹⁸Г. Пүрэвбат. Богдын бошго буюу өвгөдийн гэрээслэл. News.mn. 2011 оны 03 сарын 07

бүх хүмүүст бий болгох ёстой байв. Алба хаагч, нийт хамт олны энэ хүлээж байсан итгэл, найдварыг нь биелүүлэх найдвар байна уу? Бодит байдал дээр цагдаагийн алба үйл ажиллагааны үр дүнг яаж дээшлүүлэх, ард иргэдийг хэрхэн амар тайван амьдруулах вэ гэсэн олон асуулт, хариулт хүлээж, тулгамдсан хэвээр л байна.

Гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааны үр өгөөжийг хэрхэн дээшлүүлэх, нийтийн хэв журам хамгаалах ажлыг яаж боловсронгуй болгох, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлыг ард иргэдийн дунд хэрхэн зохион байгуулах гээд бүх асуудлууд нь зөвхөн бидний шат шатны удирдах бүрэлдэхүүний оновчтой томилгоо, гар нийлэмжтэй хамтын ажиллагаа, хамт олны идэвх санаачлагын үр дүнд л хэрэгжиж, ард иргэд амгалан тайван ажиллаж хөдөлмөрлөх нөхцөл бодит утгаараа бүрдэнэ.

...Хүний хүмүүжлийн асуудал, ёс суртахуун, хүмүүнлэг байх тухай маш ихээр яригдаж байна. Монголчууд бид хүнийг хүн болгоход өөрсдийгөө судлаад, амьдралын бүх хэмнэл, гэр бүл бололцох, хүүхэд төрүүлэх, хүүхдээ хэвлийдээ тээх, өсгөх гээд ерөөсөө алхам тутамдаа муу авьяас бүрийг хаагаад, дандаа сайн эрдэм нь гарах, хүнийг хүнлэг болгох, иргэншүүлсэн Буддын соёлтой ард түмэн. Энэ бүхэн шинжлэх ухаанаар нотлогдсон...¹⁹.

Олон улсын жишиг, манай улсын нийгмийн харилцааг эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулалт хийж ирсэн түүхэн уламжлал, энэ чиглэлийн эрдэмтдийн судалгааны ажлын үр дүнгээс үзэхэд цагдаагийн алба, үйл ажиллагаа нь ганцхан цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн орчинд өөрчлөлт, шинэчлэлт хийснээр үр дүнд хүрэхгүй болох нь харагдаж байна.

Асуудлыг доорхи байдлаар авч үзвэл илүү оновчтой байхаар ажиглагдаж байна:

➤ Хүнийг хүн болгож байсан монгол ухаан, монгол үндэстний уламжлал, ёс заншил, шашин шүтлэг, хүмүүжлийн зан үйлийг сургалтын бүх шатанд (эцэг, эх, ясли, цэцэрлэг, бага, дунд сургууль, коллеж, их дээд сургууль, мэргэжил дээшлүүлэх, давтан сургалт гэх мэт), төрийн цэгцтэй тууштай бодлогоор дэмжие, олон нийтийн хүчинд тургуурлан сэргээе, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох. Эхлээд бүгдээрээ монголын уламжлалт, ёс заншил, зан үйлдээ тулгуурлан шинжлэх ухаан, технологийн дэвшил ашиглан монгол шинэ үеэ хүмүүнлэг болгоё.

➤ Төр, засгийн улс төр, эдийн засгийн тогтвортой байдал, оновчтой, зөв бодлого, зохицуулалт, тэдний зөв үлгэр дууриалал, шударга хүн болж ярих биш, харин шударга ёсыг бодит утгаар нь ард түмэнд нүдээр үзүүлж, биеэр нь мэдрүүлж чаддаг, шударга, хүмүүнлэг байх тэр орчинг бүрдүүлэе,

➤ Цагдаагийн албаны шат шатны удирдлагын шударга томилгоо, удирдлагын арга барил, зөв менежмент, алба хаагчдын сэтгэл зүйг өөдрөг, ирээдүйдээ итгэлтэй шударга ажиллуулахын тулд нийгмийн болон эрх зүйн хамгаалалтын тогтолцоог шинэ шатанд гаргаж, тэдний идэвхтэй үйл ажиллагааны үндсэн дээр иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг дээрхи “турвалсан уялдаа холбооны” үр дүнд бидний хүсээд байгаа тэр өөрчлөлт, шинэчлэлт бодит утгаараа ард иргэдэд эерэгээр мэдрэгдэх боломжтой гэж тодорхойлж болохоор байна.

Тодруулбал цагдаагийн албаны, ажлын үр өгөөжийг сайжруулахын тулд нийгмийн харилцааг бүхэлд нь цогц байдлаар авч үзэх, ард иргэдийн эрүүл мэнд, уламжлалт, ёс заншил, шашин шүтлэг, эрх зүйн хүмүүжил, эрх зүйн мэдлэг, эрх зүйн соёл, ахмад настны үлгэр дууриалал, мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоон дахь төрийн оновчтой цогц бодлого, зохицуулалтын үндсэн дээр, цагдаагийн ерөнхий газрын боловсон хүчний оновчтой, шударга бодлогын хүрээнд, цагдаагийн албаны шат шатны удирдах бүрэлдэхүүний ажлын менежментын үр дүн, өндөр зохион байгуулалт, хариуцлагын тогтолцоо, алба хаагчдын

¹⁹ Г. Пүрэвбат. Лекц. Монгол тэмүүлэл. 2014. www.mongoliandream.mn > Үзэл бодол

албаныхаа төлөө гэсэн дотоод сэтгэл, зүтгэлийн үр дүнгээр л цагдаагийн байгууллагын өмнө тавигдаж байгаа зорилго, зорилтыг хангаж, ард түмний хүсэн хүлээж байсан тэр итгэлийг олж, биелүүлэх боломж байгаа нь судалгааны явцад ажиглагддаг.

Хүн болгон хариуцлагаа ухамсарласан эв эеийг хичээсэн эрүүл биетэй саруул ухаантай боловсон хүчинтэй, өөрөөрөө бахархасан Монгол хүнтэй тийм нийгэмд амьдармаар байна²⁰.

Авах хүнд нэг үг эрдэм, хаях хүнд мянган үг улиг. Монгол хүний авах гээхийн мэргэн ухаанаар оюун бодолдоо тунгаан болгоогтүн.

²⁰ . “Монгол тэмүүлэл”. Олон нийтийн санал. <http://www.mongoliandream.mn/index>.